Нэг. Нийтлэг зүйл

Нэгдүгээр зүйл. Дүрмийн зорилт

1. Энэхүү дүрмийн зорилго нь байгууллагын болон сургуулийн хамт олноос эрхэмлэх үнэт зүйлсэд тулгуурлан оюутан суралцах үйл ажиллагаандаа баримтлах ёс суртахууны зарчим, дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол саналыг хүлээн авах, хянан шийдвэрлэх, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх, сургууль, багшийн нэр төрийг хамгаалж ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1. Энэ журам нь ОТИС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрөөр суралцаж байгаа нийт суралцагчдад хамаарна.

1. ОТИС-ийн суралцагч суралцах хугацаандаа баримтлах ёс зүйн нийтлэг зарчим:
    1. хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах
    2. хууль дээдлэх
    3. хүнлэг энэрэнгүй байх, соёлч боловсон харилцааг эрхэмлэх
    4. шударга ёсыг баримтлан, өндөр сахилга, ёс суртахуунтай байх
    5. төлөв, түвшин байх
    6. эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх

Хоёр: Суралцагчийн ёс зүйн хэм хэмжээ

Хоёрдугаар зүйл. Суралцагчийн ёс зүйн хэм хэмжээ

2. Суралцагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйн дараах хэм хэмжээг дагаж мөрдөнө.
    1. сургуулийн дүрэм, дотоод журам, ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хууль, дүрэм журмыг уншиж судлан сахин чанд дагаж мөрдөх
    2. эрдэм мэдлэг, оюунлаг байдлыг эрхэмлэж цаг ямагт өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлэх
    3. багш, ажилтан, бусад суралцагчийн тавьсан зүй ёсны шаардлагыг хүлээн авах, алдаа дутагдлаа засах
    4. хичээлийн хөтөлбөр, цагийн хуваарийн дагуу сургалтын ажиллагаанд идэвхтэй оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээлээс хоцрохгүй, таслахгүй байх, хичээлийн дундуур орж, гарч үймүүлэхгүй байх зэргээр сургалт хүмүүжлийн ажил болон бусдад хүндэтгэлтэй хандах
    5. сургуулийн өмч хөрөнгийг ариг гамтай, зориулалтын дагуу зөв зохистой ашиглах
    6. бусдыг хүндэлж соёлтой харьцах, мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэн дээдлэх
    7. зөв боловсон хувцаслах

2. Дараах тохиолдолд оюутныг ёс зүйн зөрчил гаргасанд тооцож хариуцлага хүлээлгэнэ
    1. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл таслах, зүй бус үйлдлээ нуун дарагдуулах зорилгоор худал ярих, хуурамч бичиг баримт бүрдүүлэх
    2. бусдын өмчлөлийн зүйлийг хулгайлах, дур мэдэн авч ашиглах

3. хичээлийн цагаар орж гарах, утсаар ярих, бохь зажлах, хөгжим сонсох, тоглоом тоглох, унтах, ярих, интернэт ашиглах зэргээр сургалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг хэл амаар доромжлох, гүтгэх, дарамтлах, хүч хэрэглэх
4. бусдыг хуурч мэхлэх, худал цуурхал тараах, хувь хүний хувийн нууцыг тараах, задлах
5. шалгалтын журам зөрчих, шалгалтын явцад бусдад мэдээлэл өгөх, авах, шалгалтын болон сургалтын материалыг хуулах, нуун дарагдуулах, өөрчлөх, хориглосон тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах, бусдын өмнөөс шалгалт өгөх болон бусдыг өөрийн өмнөөс шалгалтад оруулах
6. бусдын ажлыг хуулах замаар эсвэл өөр хичээл дээр үнэлгээ авсан болон бусдыг гүйцэтгэсэн даалгаврыг дахин үнэлүүлж оноо авах
7. бие даалтын болон курсийн ажил, эрдэм шинжилгээний ажил хийх явцдаа бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй ашиглах, зохиогчийн нэр, ашигласан материал, эх сурвалж зэргийг дурдахгүй орхих, бусдын санааг өөрийн болгож бичих, хэвлэх, нийтлэх, нийтэд түгээх
8. багш, ажилтан, бусад суралцагсад, иргэдтэй зүй бус харьцах, үг хэлээр доромжлох, үл хүндэтгэх
9. сургуулийн байранд хэт бариу эсвэл хэт задгай, этгээд гажуу хувцаслаж ирэх
10. сургуулийн орчинд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хутга мэс, бусад зүйлсийг зэвсгийн чанартайгаар биедээ авч явах, хадгалах, сургуулийн гаднах тамхи татах цэгээс бусад орчинд утаат тамхи болон электрон тамхи татахгүй байх;
11. сургуулийн орчинд хөзөр, даалуу, компьютерын тоглоом гэх мэт мөрийтэй тоглоом тоглох, хэт чанга дуу авиа үүсгэх
12. зохион байгуулалттай аливаа арга хэмжээний үеэр эсрэг багийнхантай муудалцах, хэрүүл зодоон үүсгэх, хонзогнох, хэл амаар доромжлох зэргээр зохисгүй үйлдэл гаргах.

Гурав: Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах байгууллага, албан тушаалтан

Гуравдугаар зүйл. Ёс дүрмийг хэрэгжүүлэх хангах байгууллага

3. Сургуулийн хэмжээнд оюутны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг дараах удирдах ажилтан, байгууллага хангаж, хяналт тавьж ажиллана:
    1. сургалтын нэгдсэн алба
    2. бүтцийн сургуулийн захирал
    3. мэргэжлийн тэнхимийн эрхлэгч, багш нар

3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт проректорын үүрэг
    1. сургуулийн ёс зүйн дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт, засвар оруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой чиглэл, удирдамж өгөх, хяналт тавих
    2. ёс зүйн зөрчил гаргагчид сахилга, хариуцлагын шийтгэл ногдуулах эсэхийг холбогдох дүрэм, журмыг баримтлан шийдвэрлэх, санал гаргах, хэлэлцүүлэх
    3. ёс зүйн зөрчил гаргагчид ногдуулах шийтгэлийг тогтоох, санал гаргах
    4. суралцагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг тогтоосон бүтцийн сургуулийн захирал, харьяалах тэнхим, анги удирдсан багшийн санал,

дүгнэлтийг үндэслэн хэлэлцэж холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд нягтлан шалгаж, дүгнэлт гаргах

3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт дэх сургалтын нэгдсэн албаны үүрэг
    1. суралцагчийн ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх асуудлаар сургуулийн захиргаанд санал оруулах, зөвлөх, албан шаардлага тавих
    2. суралцагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаарх асуудлыг бүтцийн сургуулийн захирлын санал болгосны дагуу хэлэлцэн шийдвэрлэх
    3. ёс зүйн зөрчил гаргагчид ногдуулах хариуцлагын асуудлыг шийдвэрлэхэд санал гаргах

3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт дэх бүтцийн сургуулийн захирал, мэргэжлийн тэнхимийн үүрэг
    1. суралцагчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай санал, гомдол, мэдээлэл, баримтыг хүлээн авах, асуудлыг шийдвэрлэх
    2. суралцагчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай санал, гомдлыг бүтцийн сургуулийн багш нарын хурлаар авч хэлэлцэх, шийтгэл хүлээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэх
    3. ёс зүйн зөрчил гаргасан суралцагчдад сахилгын шийтгэл ногдуулах талаар Сургалтын нэгдсэн алба болон Ректорын зөвлөлд бүтцийн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч санал оруулах, сахилгын шийтгэлийн асуудлаар санал оруулах.

Дөрөв. Ёс зүйн хариуцлага, дүрмийн хэрэгжилт

Дөрөвдүгээр зүйл. Ёс зүйн хариуцлага

4. Энэхүү ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд зөрчлийн хор уршиг, хохирлын хэр хэмжээг харгалзан дараах шийтгэлийг ногдуулна:
    1. суралцагчийн ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд дараах шийтгэлийг ногдуулна. Ингэхдээ Боловсролын ерөнхий хууль, Суралцагчийн гэрээ, ОТИС-ийн дүрэм, дотоод журам болон энэхүү ёс зүйн дүрмийг удирдлага болгоно.
        1. нээлттэй болон хаалттай сануулах
        2. бүтцийн сургуулийн болон мэргэжлийн тэнхимийн хурлаар асуудлыг авч хэлэлцэж анхааруулах
        3. хоёр буюу түүнээс дээш удаа зөрчил гаргасан буюу ноцтой зөрчил гаргасан оюутныг сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авна.

Тав. Бусад

Тавдугаар зүйл. Өргөдөл гомдол хүлээн авах, хянах

5. ОТИС-ийн нийт профессор багш ажилтан, оюутан бүр ёс зүйн зөрчлийг гарсан даруйд нь таслан зогсоох, зүй ёсны шаардлага тавих, зөвлөлд хандан ёс зүйн зохисгүй үйлдлийн талаарх мэдээллийг мэдүүлэх үүрэгтэй.

5. Суралцагч ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар багш, ажилтан оюутнаас гаргасан гомдлыг ОХ-ны НБД хүлээн авч, ОХ-ны тэргүүнд танилцуулна.

5. ОХ-ны тэргүүн гомдлыг холбогдох бүтцийн сургуулийн захиралд танилцуулж, бүтцийн сургуулийн захирал тус дүрмийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-д тус тус заасан хариуцлагыг хүлээлгэнэ.